



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Татварын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/ болон Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2015 оны 353 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТОХИРУУЛГА ХИЙХ ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ АРГЫГ СОНГОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Татварын ерөнхий хуулийн 37, 38, 39, 40 дүгээр зүйл болон Монгол Улсаас гадаад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр” /цаашид “Давхар татварын гэрээ” гэх-ийн 9 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нөхцөл, үнэ нь татварын зорилгоор түүнтэй харьцуулж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөл, үнээс ялгаатай байгаагаас татварын суурь багассан бол тухайн ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулга хийх, татварыг нөхөн ногдуулахад оршино.

1.2.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд зааснаар, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Сунгасан гарын зарчим /Arm's Length Principle/-ыг Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 37 дугаар зүйлд зааснаар тус тус ойлгоно.

1.3.Татвар төлөгч нь үнэ шилжилтийн тайлан гаргахдаа Татварын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан мөн хуулийн 40 дүгээр зүйлд заасан аргачлалаар тохируулга хийхэд энэ журмыг хэрэглэнэ.

1.4.Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлд заасан үнэ шилжилтийн тохируулга хийхдээ энэ журмыг баримтална.

1.5.Төлөөний газрын харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн хяналтад байгаа ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулга хийхэд энэ журмыг мөрдөнө.

1.6.Үнэ шилжилтийн тохируулга хийхдээ Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан “Үнэ шилжилтийн зөвлөмж”-ийг ашиглаж болно.

Хоёр.Бодит үнэ тодорхойлох зарчимд үндэслэн, татварын ногдолд тохируулга хийх

2.1.Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөлийг харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн бие даасан ажил гүйлгээний үнэ, нөхцөлтэй харьцуулахад орлого, ашиг, татварын суурьд нөлөөлөх үзүүлэлтүүд нь зөрүүтэй байдлаас хамаарч татварын суурь буурсан бол тухайн ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулга хийнэ.

2.2.Энэ журмын 2.2-т заасан бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулгыг дараах үе шатаар хийнэ.

2.2.1.харилцан хамааралтай этгээд болон хяналтад байгаа ажил гүйлгээ, түүний бодит байдлыг тодорхойлох

2.2.2.харьцуулагдах байдлын шинжилгээ хийх

2.2.3.үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох

2.2.4.бодит үнийн үр дүнг тодорхойлох

2.2.5.татварын ногдолд тохируулга хийх

2.3.Үнэ шилжилтийн тохируулгыг санхүүгийн тайлангийн жил тус бүрээр хийнэ.

**Гурав.Харилцан хамааралтай этгээд болон хяналтад байгаа ажил гүйлгээ,
түүний бодит байдлыг тодорхойлох**

3.1.Харилцан хамааралтай этгээдийг Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд зааснаар, давхар татварын гэрээтэй тохиолдолд уг гэрээний 9 дүгээр зүйлийг баримтлан тус тус тодорхойлно.

3.2.Хяналтад байгаа ажил гүйлгээг Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.42-д заасан ойлгох бөгөөд дараах ажил гүйлгээг хамааруулна:

3.2.1.хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээнд бараа материал, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон бусад хөрөнгийг борлуулах, худалдан авах, шилжүүлэх, ашиглах, солилцох, түрээслэх;

3.2.2.биет бус хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээнд лицензийн төлбөр, патент, зохиогчийн эрх, худалдааны болон барааны тэмдэг, франчайзингийн эрх, байгалийн нөөц ашиглах эрх, ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл, программ хангамж, хаяас болон гүүдвил, түрээсийн эрх, ноу-хау, бусад биет бус хөрөнгийг бий болгох, эзэмших болон өмчлөх эрхийг шилжүүлэх, ашиглах эрхийг олгох, борлуулах, худалдан авах, шилжүүлэх, ашиглах, солилцох, түрээслэх;

3.2.3.үйлчилгээтэй холбоотой ажил гүйлгээнд удирдлагын, зөвлөхийн, санхүүгийн, даатгалын, давхар даатгалын, судалгаа болон хөгжүүлэлтийн, борлуулалтын болон маркетингийн, мэдээлэл технологийн, техникийн, логистик, агентын, дистрибьютерийн, эрхийн шимтгэлийн, бусад ажил үйлчилгээ үзүүлэх, авах;

3.2.4.санхүүжилттэй холбоотой ажил гүйлгээнд бүх төрлийн зээл, хувьцаа, батлан даагч, хүү төлөгдөх бүх төрлийн санхүүжилтийн хэлбэр, хойшлогдсон төлбөр, санхүүгийн холимог хэрэгсэл зэрэг бусад санхүүгийн үйлчилгээ болон холбогдох бусад ажил гүйлгээ.

3.3.Хяналтад байгаа ажил гүйлгээ нь хоорондоо нягт холбоотой салгах боломжгүй тохиолдолд тухайн ажил гүйлгээг багцаар нь ажил гүйлгээний бодит байдлыг тодорхойлно.

3.4.Нөхөн төлбөртэй холбоотой ажил гүйлгээ

Дөрөв.Харьцуулагдах байдлын шинжилгээ хийх

4.1.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.37-д заасан харьцуулагдах байдлын шинжилгээг хийхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1.тухайн хяналтад байгаа ажил гүйлгээг хийсэн этгээдийн бизнес, зах зээл, эдийн засгийн төлөв байдал, эдийн засгийн салбарын онцлог зэргийг тодорхойлон шинжилгээ хийх;

4.1.2.харьцуулагдах байдлын хүчин зүйлсийг тодорхойлох;

4.1.3.хяналтад байгаа ажил гүйлгээ хийсэн этгээдүүдээс шалгагдах тал /tested party/-ыг сонгох;

4.1.4.харьцуулагдах ажил гүйлгээ болон этгээдийг хайх;

4.1.5.харьцуулалтын тохируулга хийх.

4.2.Журмын 4.1.1-д заасан шинжилгээг хийхдээ тухайн хяналтад байгаа ажил гүйлгээг хийсэн этгээдийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, бизнесийн стратеги бодлого, эдийн засгийн салбарын онцлог, үйл ажиллагааны бүтэц, гол өрсөлдөгчдийн талаарх мэдээлэл, удирдлага, дотоод нэгжүүдийн зохион байгуулалт бүтэц, удирдлагын тайлантай танилцах, компанийн шийдвэрт нөлөөлөх эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, санхүүгийн гол гол үзүүлэлтүүд, үйлдвэрлэлийн салбарт нөлөөлж буй хүчин зүйлс зэрэгт үндэслэнэ.

4.3.Энэ журмын 4.1.2-т заасан ажил гүйлгээний харьцуулагдах байдлыг дараах хүчин зүйлсээр тодорхойлно:

4.3.1.ажил гүйлгээний шинж чанар, түүний нөхцөлийг шинжлэхдээ ажил гүйлгээний шинж чанар, төрөл, хэлбэр, үнэ, тоо хэмжээ, гэрээний нөхцөл, хамрах хүрээ, үйлчлэх хугацаа, төлбөрийн нөхцөл, хүлээгдэж буй эдийн засгийн өгөөж зэргийг харгалзах;

4.3.2.ажил гүйлгээнд оролцсон этгээдийн группийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд гүйцэтгэсэн ажил, хүлээсэн үүрэг хариуцлага, ашигласан хөрөнгө, хариуцсан эрсдэлийг тодорхойлсон ажил үүргийн шинжилгээг дараах байдлаар хийнэ:

4.3.2.1.гүйцэтгэсэн ажил, хүлээсэн үүрэг хариуцлагыг шинжлэхдээ ажил гүйлгээнд оролцогч бүх талуудын гүйцэтгэсэн ажил үүргийн хуваарилалт, хүлээсэн үүрэг хариуцлага, группийн оролцогч талуудын ажил үүргийн хамаарал, ажиллагсдын тоо, хууль ёсны эрх зэргийг тогтоох;

4.3.2.2.ашигласан хөрөнгийг шинжлэхдээ хөрөнгийн төрөл, шинж чанар, ашигласан хугацаа, зах зээлийн үнэ, байршил, үнэ цэнэ бүхий биет бус хөрөнгө болон санхүүгийн хөрөнгийн ашигласан байдал, онцлог зэргийг тогтоох;

4.3.2.3.хариуцсан эрсдэлийг шинжлэхдээ стратегийн буюу зах зээлийн, үйл ажиллагааны, санхүүгийн, ажил гүйлгээний, тухайн улс орны, аюул ослын зэрэг эрсдэлийг удирдах, хянах, бууруулахад гүйцэтгэсэн ажил үүргийг тогтоох.

4.3.3.шилжүүлсэн хөрөнгө, ажил үйлчилгээний шинж чанарыг тодорхойлохдоо биет хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд хөрөнгийн биет шинж чанар, найдвартай байдал, хэмжээ, биет бус хөрөнгийн хувьд ажил гүйлгээний хэлбэр, хөрөнгийн төрөл, хугацаа, уг хөрөнгөөс олох өгөөжийг, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд үйлчилгээний шинж чанар, цар хүрээ зэргийг харгалзана;

4.3.4.тухайн ажил гүйлгээ хийгдсэн улсын эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо тухайн салбарын талаарх мэдээлэл, газар зүйн байршил, зах зээлд эзлэх хэмжээ, зах зээлийн түвшин, зах зээл дэх өрсөлдөөний цар хүрээ, орлуулах бараа, үйлчилгээ, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн бүс нутгийн түвшин, хэрэглэгчийн худалдан авах чадвар, үйлдвэрлэлийн өртөг, зардал, зах зээлийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн зохицуулалтын онцлог зэргийг харгалзана;

4.3.5.бизнесийн стратегийг тодорхойлохдоо шинэ санаачилга, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бүтээгдэхүүний төрөлжүүлэлт, улс төрийн нөхцөл байдал, зах зээлд нэвтрэх, тэлэх, бэхжүүлэх зорилгоор баримталж байгаа стратеги, бодлого зэргийг харгалзана.

4.4.Хяналтад байгаа ажил гүйлгээ хийсэн этгээдээс шалгагдах тал /tested party/-ыг сонгохдоо энэ журмын 4.3.2-т заасан ажил үүргийн шинжилгээнд үндэслэн хүлээсэн үүрэг хариуцлага, ашигласан хөрөнгө, хүлээх эрсдэл бага, найдвартай харьцуулагдах зүйлс олдох боломжтой талыг сонгоно.

4.5.Энэ журмын 4.1.4-т заасан харьцуулагдах ажил гүйлгээ болон этгээдийг сонгохдоо тухайн ажил гүйлгээний үнэ, нөхцөл нь харьцуулагдах байдлын хүчин зүйлсээр ижил төстэй нь тодорхойлогдсон, харьцуулагдах байдлын тохируулга хийх боломжтой, хангалттай харьцуулахуйц үзүүлэлттэй байх зарчмыг баримтлан дотоод болон гадаад харьцуулалт хийнэ.

4.5.1.дотоод харьцуулалт хийхдээ харилцан хамааралтай этгээдээс бие даасан этгээдтэй хийсэн ажил гүйлгээг сонгож, хяналтад байгаа ажил гүйлгээтэй харьцуулна;

4.5.2.гадаад харьцуулалт хийхдээ харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн бие даасан ажил гүйлгээг сонгож хяналтад байгаа ажил гүйлгээтэй харьцуулна.

4.6.Хяналтад байгаа ажил гүйлгээний үнэ, нөхцөл нь бие даасан ажил гүйлгээний үнэ, нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг Татварын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасныг баримтлан тогтооно.

4.7.Энэ журмын 4.1.5-д заасан тохируулгыг хийхдээ харьцуулагдаж байгаа ажил гүйлгээний нөхцөл болон үнийн хооронд зөрүү байгаа тохиолдолд тохируулга хийгдэх

мэдээллийн үнэн зөв, хангалттай байдал, тохируулгын тохиромжтой арга ашигласан байдал зэргийг харгалзан үр дүн нь бодитой, үнэн зөв байх зарчмыг баримтална.

4.8.Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн дараах ажил гүйлгээг энэ журмын 4-д заасан харьцуулагдах байдлын шинжилгээнд тусгайлан авч үзнэ:

4.8.1.группийн доторх үйлчилгээг группийн нэг оролцогчоос бусад оролцогчдод үзүүлсэн үйлчилгээ нь тэдгээрийн бизнесийн нөхцөл байдлыг сайжруулахад нь нөлөөлж, эдийн засгийн болон арилжааны үнэ цэнийг бий болгох зорилготой байнгын болон тохиолдлын үр ашиг хүртсэн эсэх, үйлчилгээ үзүүлэх бизнесийн шаардлага байсан эсэх, төвлөрсөн үйлчилгээ түүний төлбөрийн хэлбэр зэргийг;

4.8.2.биет бус хөрөнгийг эзэмших, бий болгох, хөгжүүлэх, хамгаалах, ашиглах, шилжүүлэхтэй холбоотой гүйцэтгэсэн ажил үүргийн хуваарилалт, тэдгээрээс хүртэж байгаа өгөөжийн бодит байдал, хүлээсэн эрсдэл, хууль ёсны эрх зэргийг;

4.8.3.зардлыг санхүүжүүлэхэд хувь оруулах гэрээ, зардал хуваах гэрээгээр оролцогч талууд нь бодитоор хөрөнгө оруулсан эсэх, энэ хөрөнгө оруулалтын хэмжээгээр өгөөж хүртэж байгаа эсэх, хүртэж байгаа өгөөжийн зөрүүгээр тэнцвэржүүлэх төлбөр авсан эсэх зэргийг;

4.8.4.бизнесийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой ажил гүйлгээг бодитоор хийгдсэн эсэх, бизнесийн шаардлага, шалтгаан байсан эсэх, өөрчлөлтийн өмнөх болон дараа нь гүйцэтгэсэн ажил үүргийн хуваарилалт, хүлээсэн эрсдэлийн шинжилгээгээр хүртэж байгаа өгөөж нь зохистой түвшинд байгаа эсэх зэргийг;

4.8.5.уул уурхайн бүтээгдэхүүнтэй холбоотой ажил гүйлгээг бодитоор хийгдсэн эсэх, гүйлгээнд оролцож байгаа талуудын уул уурхайн бүтээгдэхүүн эзэмшиж, үйлдвэрлэж байгаа байдал, гэрээний үндсэн нөхцөлүүд нь зах зээлийн шаардлагад нийцсэн эсэх, гэрээгээр гүйцэтгэсэн ажил үүргийн хуваарилалт эрсдэлийн шинжилгээгээр бизнесийн үнэ цэнийг бий болгосон эсэх зэргийг авч үзнэ;

4.8.6.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс эх үүсвэртэйгээр олборлосон уул уурхайн бүтээгдэхүүнийг харилцан хамааралтай этгээдэд борлуулсан, уг харилцан хамааралтай этгээд нь боловсруулалт хийлгүйгээр гуравдагч харилцан хамааралгүй этгээдэд борлуулсан үнэ нь олон улсын зах зээлийн зарчимд үндэслэсэн үнээс их бол энэ үнийг харьцуулагдах бие даасан үнэ гэж үзэж болно.

Тав.Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох

5.1.Татварын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан дараах аргуудаас энэ журмын 4.1-т заасан харьцуулагдах байдлын шинжилгээнд үндэслэн уг аргуудын давуу ба сул талуудыг харьцуулах замаар хамгийн тохиромжтой аргыг дангаар эсхүл хослуулан сонгож хэрэглэнэ.

5.1.1.Харьцуулагдах бие даасан үнийн арга нь хяналтад байгаа ажил гүйлгээний үнийг харьцуулж болохуйц адилхан нөхцөлд хийгдсэн бие даасан ажил гүйлгээний үнэ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг харьцуулан тодорхойлно. Энэ аргыг хэрэглэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

5.1.1.1. зах зээлийн нөхцөл, ажил үүргийн гүйцэтгэл, ажил гүйлгээний шинж чанарын ялгаатай байдлаас шалтгаалан ажил гүйлгээний үнэ тогтворгүй байх тул энэ аргыг хяналтад байгаа, бие даасан ажил гүйлгээний хоорондох харьцуулагдах түвшин өндөр байх, бодит, үнэн зөв тохируулга нь материаллаг үнийн зөрүүг арилгасан байх гэсэн хоёр нөхцөл зэрэг хангагдсан тохиолдолд хэрэглэх боломжтой.

5.1.1.2. энэ арга нь ажил гүйлгээний шинж чанар /нэр, төрөл, биет шинж тэмдэг, чанарын үзүүлэлт, тоо хэмжээ/ адилхан, зах зээл болон эдийн засгийн нөхцөл ижил түвшинд хийгдсэн тохиолдолд хэрэглэхэд тохиромжтой.

5.1.1.3. энэ аргыг хэрэглэх хамгийн тохиромжтой байдлыг тодорхойлохдоо ажил үүргийн шинжилгээнээс илүү эдгээр харьцуулж буй ажил гүйлгээний ижил төстэй шинж чанар, нөхцөлүүдийг харгалзан үзнэ.

5.1.1.4. татвар төлөгч нь дотоод харьцуулагдах ажил гүйлгээ хийгээгүй эсвэл ажил гүйлгээний шинж чанар, нөхцөл нь харьцуулах боломжгүй тохиолдолд гадаад харьцуулагдах ажил гүйлгээг ашиглана.

5.1.2. Дамжуулан борлуулах үнийн аргыг татвар төлөгч харилцан хамааралтай этгээдээс бараа бүтээгдэхүүн худалдан авч, харилцан хамааралгүй этгээдэд дамжуулан борлуулсан үед хэрэглэнэ. Дамжуулан борлуулагчийн гүйцэтгэсэн ажил, үүргийн хэмжээнээс борлуулалтын үнэ шууд хамаарна. Энэ аргыг хэрэглэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

5.1.2.1. харилцан хамааралгүй этгээдэд дамжуулан борлуулсан үнээс харьцуулагдахуйц нийт ашиг /дамжуулан борлуулах үнийн ашгийн түвшин/-ийг хасаж харилцан хамааралтай этгээд хооронд шилжүүлсэн бараа, бүтээгдэхүүний бодит үнийг тодорхойлно.

5.1.2.2. бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу дамжуулан борлуулах үйл ажиллагааны ашиг нь борлуулалт, үйл ажиллагаа зардлыг нөхөхийн зэрэгцээ ажил үүргийн шинжилгээнд үндэслэсэн бодиттой, үнэн зөв ашгийг хүртсэн байх шаардлагатай.

5.1.2.3. энэ арга нь харьцуулагдах бие даасан үнийн аргыг бодвол бараа, бүтээгдэхүүний шинж чанар, нөхцөлөөс илүү нийт ашиг, түүнийг олоход зарцуулсан зардлыг харуулсан тусгайлсан ажил үүргийн шинжилгээнд үндэслэнэ.

5.1.2.4. хяналтад байгаа болон бие даасан ажил гүйлгээний харьцуулагдахуйц үзүүлэлтүүд нь бараа, бүтээгдэхүүний шинж чанараас гадна бусад бүх үзүүлэлтийг хамардаг тул харьцуулагдах бие даасан үнийн аргаас илүү бодит үр дүнг гаргадаг.

5.1.2.5. бараа бүтээгдэхүүнийг дахин боловсруулсан, биет бус хөрөнгийг дахин хөгжүүлсэн зэрэг бараа, бүтээгдэхүүнийг дахин боловсруулснаар их хэмжээний ашиг хүртсэн үед энэ аргыг хэрэглэхэд хүндрэлтэй. Харин дамжуулан борлуулагч нь бага хэмжээний ашиг хүртсэн үед хэрэглэхэд илүү тохиромжтой юм.

5.1.2.6. материаллаг үнийн зөрүү нь дамжуулан борлуулах ашигт нөлөө үзүүлэх тохиолдолд тохируулга нь энэ зөрүү заавал арилгасан байх ёстой.

5.1.3. Өртөг дээр нэмэх арга нь харилцан хамааралтай этгээдэд борлуулсан ажил гүйлгээнээс нийлүүлэгчийн хүртсэн нийт нэмэгдэл ашгийн хэмжээгээр тодорхойлно. Энэ нэмэгдэл ашгийн хэмжээ нь нийлүүлэгчийн гүйцэтгэсэн ажил, үүргээс шууд хамаарна. Энэ аргыг хэрэглэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

5.1.3.1. энэ аргаар хяналтад байгаа ажил гүйлгээний бодит үнийг нийлүүлэгчийн борлуулсан ажил гүйлгээний өртөг дээр харьцуулагдахуйц нийт ашгийн нэмэгдлийг нэмж тодорхойлно.

5.1.3.2. энэ аргыг хэрэглэж байгаа үед ажил үүргийн шинжилгээ, шалгагдах талууд болон харьцуулагдахуйц компаниудын эдийн засгийн нөхцөл байдал зэрэг бусад харьцуулагдахуйц үзүүлэлтүүдийг ашиглах, хяналтад байгаа, бие даасан ажил гүйлгээний өртгийн суурь, нийт ашгийн нэмэгдлийн харьцуулах шаардлагатай.

5.1.3.3. бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн шууд болон шууд бус зардлаар өртгийн суурийг тооцно. Эдгээр зардлууд нь нийлүүлэгчийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өртгөөр тодорхойлогдох тул нийлүүлэгчийн ажил үүргийн шинжилгээг нарийвчлан хийх шаардлагатай болдог.

5.1.3.4. харилцан хамааралтай этгээд хоорондоо хагас боловсруулсан бүтээгдэхүүн борлуулсан эсвэл цогц үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд энэ аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой.

5.1.4. Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга нь тухайн татвар төлөгчийн хяналтад байгаа ажил гүйлгээний цэвэр ашигтай холбоотой тохиромжтой суурь үзүүлэлтүүдийг бие даасан гүйлгээний харьцуулагдахуйц мөн үзүүлэлтүүдтэй харьцуулж тодорхойлно. Цэвэр ашгийн харьцаа болон суурь үзүүлэлтийг цэвэр ашгийн эсвэл ашгийн түвшний итгэлцүүр

гэж нэрлэдэг. Энэ аргыг хэрэглэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

5.1.4.1. дамжуулан борлуулах үнийн арга, өртөг дээр нэмэх аргуудтай харьцуулахад энэ арга нь ажил гүйлгээний нийт ашгийг бус цэвэр ашгийн түвшинг хэрэглэдэг. Энэ аргын гол дутагдалтай тал нь цэвэр ашгийн түвшинд ашиглаж буй тоног төхөөрөмжийн бүтээмж, удирдлага, хүний нөөцийн чадавхи, өрсөлдөх чадвар зэрэг хүчин зүйлсийн нөлөөлөл их байдаг.

5.1.4.2. цэвэр ашгийн эсвэл ашгийн түвшний итгэлцүүрийг сонгохдоо ажил гүйлгээний нөхцөл, шинж чанарт тохируулан сонгосон итгэлцүүрийн сул ба давуу тал, ажил гүйлгээний шинж чанарт тохирсон итгэлцүүрийг хэрэглэх, итгэлцүүрийг тооцох бодит мэдээллийн боломж, хяналтад байгаа болон бие даасан ажил гүйлгээний хоорондох харьцуулагдах байдлын түвшин, харьцуулалтын тохируулга нь материаллаг зөрүүг арилгах байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

5.1.5. Ажил гүйлгээний ашиг хуваах арга нь хяналтад байгаа ажил гүйлгээний нэгдсэн ашгийг харилцан хамааралгүй этгээдийн харьцуулагдахуйц нөхцөл, ижил зарчимд үндэслэн хуваарилдаг. Энэ аргыг хэрэглэхийн тулд дараах хоёр хандлагыг ашиглана.

5.1.5.1. үлдэгдэл шинжилгээний хандлага нь оролцогч талуудын өвөрмөц, үнэ цэнэтэй оролцооны түвшинг тухайн ажил гүйлгээнд гүйцэтгэсэн ажил үүргийг тогтоох харьцуулагдах мэдээлэлд үндэслэн тодорхойлно. Дараа нь оролцогч тус бүрийн холбогдох оролцооны түвшинг харгалзан үлдэгдэл ашгийг хуваарилна.

5.1.5.2. оролцооны шинжилгээний хандлага нь хяналтад байгаа ажил гүйлгээнээс хүртсэн оролцогч талуудын нийт ашгийг тухайн оролцогч талуудын гүйцэтгэсэн холбогдох оролцоонд үндэслэн хуваарилна.

5.1.5.3. оролцооны түвшинг тодорхойлохдоо оролцогч бүрийн ашигласан хөрөнгө, гүйцэтгэсэн ажил үүрэг, хүлээсэн эрсдэл болон боломжит зах зээлийн мэдээлэлд зэргийг үндэслэл болгоно.

5.1.6. Үнэ шилжилтийн ерөнхий зарчимд нийцсэн уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг тооцох арга /Зургаа дахь арга/ нь харилцан хамааралтай этгээд хооронд уул уурхайн бүтээгдэхүүн борлуулсан тохиолдолд борлуулалтын үнийг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн дараах байдлаар тодорхойлно;

5.1.6.1. олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын уул уурхайн бүтээгдэхүүний дундаж үнийг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан зах зээлийн үнийн эх сурвалжийн үнэд үндэслэн гаргана;

5.1.6.2. уул уурхайн бүтээгдэхүүний агуулгын хувийг тооцохдоо тухайн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, агуулга найрлагын талаарх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэнэ.

Зургаа. Бодит үнийг тодорхойлох, татварын ногдолд тохируулга хийх

6.1. Бодит үнэ болон бодит үнийн хязгаарыг дараах байдлаар тогтооно:

6.1.1. харьцуулагдахуйц үзүүлэлтийн бодит байдлын эсвэл харьцуулагдах байдлын шинжилгээгээр тодорхойлогдох, тохируулга хийх боломжгүй материаллаг зөрүү байдаг тул бодит үнийг тодорхойлох хязгаар нь өргөн хэмжээтэй байх бөгөөд үүнийг бодит үнэ тодорхойлох нийт хязгаар гэж ойлгоно.

6.1.2. харьцуулагдах байдлын шинжилгээний үр дүнд гарсан энэ нийт хязгаараас хамгийн их болон хамгийн бага утгыг хасаж, дундаж квартил утгаар тухайн ажил гүйлгээний бодит үнийг тооцно.

6.1.3. хяналтад байгаа ажил гүйлгээний үнэ нь энэ журмын 6.1.2-т заасан хязгаараас доогуур байгаа тохиолдолд энэ үнэ интер квартилыг ашиглан тооцож гаргасан дундаж утга /медиан/ хоёрын зөрүүгээр тохируулга хийнэ.

6.2. Татвар төлөгч нь энэ журмын 6.1-д заасан хяналтад байгаа ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлсон үйл ажиллагаа, үр дүнг Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасан үнэ шилжилтийн тайланг гаргаж татварын албанд тушаана.

Долоо.Татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийж, татварыг нөхөн ногдуулах

7.1.Энэ журмын 4.3-т заасан шинжилгээний үр дүнд Татварын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.3.2, 37.3.3-т заасан ажил гүйлгээ хийх бодит шаардлага байгаагүй, талууд харилцан хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бодит ажил гүйлгээ хийгдээгүй нь тогтоогдвол татварыг нөхөн ногдуулна.

7.2.Татварын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6-д заасны дагуу татварын алба өөр бусад татвар төлөгчийн нээлттэй мэдээлэлд үндэслэн, эсхүл татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас сонгож харьцуулах замаар татварыг нөхөн ногдуулна.

7.3.Татвар төлөгч нь үнэ шилжилтийн тайлан гаргаагүй, эсхүл татварын ногдлоо дутуу тодорхойлж тайлагнасан бол татварын алба Татварын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн тохируулгыг хийж, татварыг нөхөн ногдуулна.

7.4.Татвар төлөгчийн хяналтад байгаа ажил гүйлгээнд үндсэн тохируулга хийсний үр дүнд бий болсон зөрүүг хувь хүний орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зорилгоор ногдол ашиг гэж үзэж хоёрдогч тохируулгыг хийнэ.

7.5.Үнэ шилжилтийн тохируулга, татварын нөхөн ногдуулалт нь зөрүү үүссэн тохиолдолд татвар төлөгч нь холбогдох Давхар татварын гэрээний 9, 25 дугаар зүйлийг үндэслэн татварын давхардлыг арилгуулах хүсэлтээ харьяалагдах улсын эрх бүхий этгээдэд гаргасан, эрх бүхий байгууллагууд харилцан тохирох үйл ажиллагааг хэрэгжүүлж, тохиролцоонд хүрсэн бол татварын алба энэ тохиролцоонд үндэслэн нийцүүлэх тохируулгыг хийнэ.

Найм. Бусад

8.1.Татвар төлөгчийн мэдээллийг ажил гүйлгээний үнийн харьцуулалт хийх зорилгоор холбогдох гуравдагч этгээдээс гаргуулан авсан тохиолдолд уг мэдээллийг нууцална.

8.2.Татварын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6-д заасан үл мэдээлэгч улс, бүс нутгийн жагсаалтад Монгол Улстай татварын зорилгоор мэдээлэл солилцдоггүй болон эрсдэлтэй татварын тогтолцоотой улс, бүс нутгийг хамруулах бөгөөд энэхүү жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор, жагсаалтад өөрчлөлт орсон бол ажлын 10 өдрийн дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага албан ёсны цахим хуудсаараа нийтэд мэдээлнэ.